



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 8 сарын 12 өдөр

Дугаар А/49

Даланзадгад

Хоол хүнсээр дамжих өвчний үеийн  
хариу арга хэмжээ авах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хоол хүнсээр дамжих өвчин гарсантай холбогдуулан төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс /М.Цэндсүрэн/-д үүрэг болгосугай.
2. Эрсдэлийн үеийн бүртгэл, мэдээлэл, харилцаа холбооны асуудлыг хариуцан, халдварын голомтод байсан иргэн бүрийн мэдээллийг тодорхой болгох, өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдол бүрийг бүртгэн мэдээлж ажиллахыг Хяналт шинжилгээ мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хариуцан, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга захирал нарт үүрэг болгосугай.
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн тооцоо, зарцуулалт, санхүүжилтийн асуудлыг хариуцан ажиллахыг Эрүүл мэндийн газрын эдийн засагч /М.Нямдулам/-д даалгасугай.
5. Олон нийтэд мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гүйцэтгэж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв, айл өрхийн ариутгал халдваргүйтгэлийг цаг хугацаанд нь хийж ажиллахыг сум өрхийн эрүүл мэндийн төв сум дундын эмнэлгийн дарга нарт, нийтийн үйлчилгээний байгууллага, талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төвд үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ӨНӨРЖАРГАЛ



461190053